

**Шидэт хүүрийн үлгэр дэхь Тугал ханшаартын бүлгийн
эх бичиг болон орчуулгын зарим асуудалд**

Хүрэлбаатарын БИРААСҮРЭН*
Монгол Улс, Улаанбаатар,
Шинжлэх ухааны академийн
Хэл зохиолын хүрээлэнгийн
Төвөд судлалын салбар

Received: Aug 08, 2025 | **Revised:** Dec 23, 2025 | **Accepted:** Dec 26, 2025

Хураангуй: Шидэт хүүрийн үлгэрийн эх бичиг болон орчуулгын талаар зарим ажиглалт хийв. Уг дурсгал нь голдуу монгол бичгээр тод үсгээр үлдэж хоцорсон байдаг. Академич Ц.Дамдинсүрэн төвөд монгол шидэт хүүрийг харьцуулан судлах санал дэвшүүлсэн. Европт гарсан орчуулгууд голдуу тод бичгийн эх сурвалжийг ашигласан байна. Тиймээс дээрх саналыг харгалзан үзэж төвөд монгол хэл дээрх Шидэт хүүрийн үлгэрүүдийг тулгаж нягтлах, зөв уншиж тодруулах, хуучирсан үгийн тайлбар хийх ажлууд чухал байна. Мөн үүний дашрамд гадаад хэл дээр гарсан гэх орчуулгууд хэр зэрэг нягт нямбай болсныг мөшгөн тодруулах хэрэгцээ шаардлага байна.

Түлхүүр үг: Шидэт хүүр, тод үсэг, Галсан Гомбоев, Б.Я.Владимирцов, төвөд шидэт хүүрийн үлгэр.

**Some issues of the original text and translation of the chapter
“Masang’s adventure” from the Vetala tales**

BIRAASUREN Khurelbaatar
The Sector of the Tibetan Studies,
Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: Some observations were made on the original text and translation of the Vetala tale. The monument is mostly preserved in Mongolian traditional script and toda scripts. Academician Ts. Damdinsuren proposed a comparative study of the Tibetan-Mongolian Vetala tales. Translations published in Europe mainly based on monument of toda scripts. Therefore, taking into account the above suggestion, it is important to compare and contrast the Vetala tales in Tibetan-Mongolian, clarify their correct reading, and explain obsolete words. In addition, there is a need to clarify how accurate the translations that have been published in foreign languages are.

* © Х.Бираасүрэн 2025
Email: biraasuren@gmail.com

Key words: *Vetala tales, toda scripts, Galsan Gomboev, B.Y.Vladimirtsov, Tibetan variation of Vetala tales.*

1. Удиртгал

Энэхүү өгүүлэлд монголчуудын дунд ихэд дэлгэрсэн Шидэт хүүрийн үлгэрийн эх бичгийн судалгааг нарийсган тод үсгийн, монгол бичгийн, төвөд хэл дээрх хоёр янз сурвалжийг ашиглан гүйцэтгэсэн ба үүнээс гадна тод бичгийн эхэд тулгуурлан хийсэн Галсан Гомбоев болон Б.Я.Владимирцов нарын орчуулгад хийсэн зарим ажиглалтаа багтаав.

2. Судалгааны арга

Эх сурвалжуудыг бүртгэн цуглуулж харьцуулан ажиглалт хийсний дараа орос хэл дээрх орчуулгуудыг харьцуулан тулгаж, дээрх үлгэрийн товч агуулгыг энгийн ойлгомжтой байдлаар төвөд, орос хэлнээс орчуулж тайлбарласан.

3. Судалгааны хэсэг

Монголчуудын дунд ихэд түгэн дэлгэрсэн үлгэрийн нэг бол гарцаагүй Шидэт хүүр болно. Угтаа Энэтхэгт анх үүсээд хөрш зэргэлдээ орон болох Төвөдөөр дамжин боловсорч, Монголчуудын дунд дэлгэрсэн бөгөөд одоогийн бидний оршин буй газар нутгаас ч алс хол түгэн дэлгэрсэн нь эрхбиш манай монголчуудын түүхэн газар нутгийн хил хязгаартай холбогдох болов уу.

Энэхүү өгүүлэлдээ Шидэт хүүрийн үлгэрийн доторх Тугал ханшаартын бүлгийн эх бичгийн болон орчуулгын зарим асуудалд анхаарал хандуулахыг зорилоо. Академич Ц.Дамдинсүрэн нэгэнт тэмдэглэн хэлсэнчлэн бид эх бичгийн судалгааг төвд сурвалжтай нь харьцуулан судлах хэрэгтэй болоод байна. «Монгол “Шидэт хүүрийн үлгэр”-ийг Орос ба европт олон удаа орчуулж хэвлэсэн байвч төвд “Шидэт хүүрийн үлгэр”-ийг орчуулж хэвлэсэн судалсан нь тун бага баймуй. Төвд “Шидэт хүүрийн үлгэр” байдаг гэж мэдээ хэдийн гарсан боловч төвд эх хэвлэгдээгүй ба орчуулга саяхан болтол хэвлэгдээгүй байлаа.» (Дамдинсүрэн, 1963: 4-5)

Тухайн цаг үедээ Ц.Дамдинсүрэн гуай эх бичиг сурвалжийн олдоц ховор байдлаас шалтгаалан төдийлөн нарийвчилж хийж чадаагүй судалгааг өнөө үед үргэлжлүүлэн хийх боломж гарч байна. Миний бие Төвд шидэт хүүрийн хэд хэдэн хувилбарыг олсон байгаа ба түүндээ тулгуурлаж дээрх өгүүллийг бэлдсэн юм. Энэ явцад сонирхолтой гэж хэлж болохуйц зарим ажиглалт хийв. Эх бичгийг зөв тайлж уншиж байж дараагийн шат болох орчуулгын ажил хийгдэх учиртай.

Орос хэлэнд анх 1865 онд алдарт Ковалевскийн шавь Казанийн их сургуулийн багш буриад лам Галсан Гомбоев хийсэн ба уг орчуулгын оршилд академич Шифнер тэмдэглэн хэлэхдээ: «Халимаг-монгол сурвалжийн бүрэн, зарим талаараа жаахан чөлөөтэй ч гэмээр орчуулга энд анх удаа гарч байгаа бөгөөд энэ нь манай эх орны доторх дорно зүгийн гаралтай ард түмний дунд эргэлдэн бүхүй яруу найргийн бүтээлүүдийг танилцуулахаас гадна, эрт дээр үеэс нааш Оросын ард түмний дунд түгэн дэлгэрсэн аман зохиол үлгэр, туужуудтай нарийн нягт харьцуулан судлахад чухал ач холбогдолтой байгаасай гэж хүсэх л үлдлээ» (Галсан Гомбоев, 1865: 6)

Дараа нь 1938 онд Зөвлөлтийн монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов «Шидэд хүүр» нэрээр орчуулж гаргасан. «1923 онд алдарт эрдэмтэн Владимирцовын халимаг хэлнээс орос хэлэнд орчуулж хэвлүүлсэн “Шидэт хүүрийн үлгэр” болбоос хамгийн бүрэн сайн эхээс хамгийн нягт сайнаар хийсэн орчуулга болмуй.» (Дамдинсүрэн, 1963: 3)

Дээр дурдсан орос хэл дээрх хоёр орчуулга нь тод болон монгол бичгээс хийгдсэн бөгөөд энэ нь ямар нэгэн байдлаар орчуулгын чанарт нөлөөлөх магадлал бий гэж үзлээ. «Төвөдөд дэлгэрсэн “Шидэт хүүрийн үлгэр” маш их засварлагдан өөрчлөгдөж, Төвөдийн хөрснөө идээшин зохицож, тэдний амьдралын хэв маягийг нэвт шингээсэн.

Гэсэн хэдий ч “Шидэт хүүрийн үлгэрүүд” Энэтхэгт дэлгэрэх явцдаа Буддын шашны нөлөөнд орж сүрхий өөрчлөгдсөн байхыг ч бид үгүйсгэх аргагүй юм. Асуудал нь юунд байна гэвэл бид Төвөд орны талаар маш багыг мэддэгээс бидний хувьд тайлагдашгүй нууц хэвээр үлдсэн ба төвөдийн утга зохиолын талаарх ойлголт ч мөн адил бүрхэг байна. Тиймдээ ч Шидэт хүүрийн үлгэрийн төвөд хувилбартай одоогоор бидний хэн маань ч үзэж танилцаагүй байна. Энэ хувилбарын талаар төвөдийн эрдэмтэй лам нар ч зохиол бүтээлдээ цухас дурддаг ба мөн түүнчлэн манай нэртэй аялагч Потанин болон английн цэргийн офицер О Коннор нар сонсож дуулснаа тэмдэглэсэн мэдээ бий.» (Владимирцов, 1958: 9-10)

Академич Цэндийн Дамдинсүрэн 1962-1963 оны хооронд Шидэт хүүрийн үлгэрийг Төвд эх болон уйгуржин монгол бичгийн хадмалтайгаар хэвлүүлсэн билээ. Тэрээр уг хэвлэлийн оршилд ерөнхий тойм мэдээг хангалттай сайн өгсөн байна. Түүний үзэж буйгаар Шидэт хүүрийн холбогдол бүхий судалгааны ном бүтээлүүд цаашдын судалгаа хийхэд чухал түлхэц үзүүлэхийг цохон тэмдэглэсэн.

Миний бичих өгүүллийн гол зорилго бол шидэт хүүртэй холбогдол бүхий дээрх судалгаа болон орчуулгын бүтээлүүдэд эх бичгийн үүднээс дүн шинжилгээ хийх явдал байв. Тодруулбал ойрмогхон олдлоод байгаа төвөд хэд хэдэн эхийг монгол бичгийн болон тод үсгийн эхүүдтэй харьцуулах улмаар тэр эхүүдэд үндэслэн хийсэн орос орчуулгуудын зарим онцлог талуудыг хөндөж ярих болно.

Ингээд юуны түрүүнд үлгэрийн товч агуулгыг танилцуулах нь зүйтэй гэж бодож байна. Тугал ханшаартын бүлэг Шидэт хүүрийн үлгэрийн монгол болон тод үсгээр буй хувилбарын гурав дахь үлгэрт хамаарч байна. Төвд хувилбаруудад ихэнхдээ эхэн хавьцаа тохиолдох боловч зарим тохиолдолд нэлээд хойгуур орж хэвлэгдсэн тохиолдол ч гарч байна. Юутай энэ талаар эргэн ярих болно. Тэгэхээр үлгэр ингэж эхэлдэг. Нэг маш ядуу ганц бие эр гарч байна. Түүнд хөрөнгө хогшил гэвэл ганцхан үнээ бий. Сүү саалийг нь хүртэхийн тул ойр хавиар бухын эрэлд гардаг. Харамсалтай нь олддоггүй ба өлсөж ундаасч үхэхээс айсандаа өөрөө үнэндээ явж байна. Тэгээд сар нь гүйцсэн хойно ямар тугал гарахыг үзтэл, үхэр толгойтой хүн биетэй, тэгсэн хэрнэ үхрийн сүүлтэй амьтан буюу үхэр хүн хоёрын эрлийз гардаг. Үүнд уурссан эзэн тугалыг харваж алахыг завдсанд тэрээр амь өршөөхийг гуйж, ачийг нь хариулахаа амлана. Тугал эзнээсээ салж ой руу ороод, явах замдаа ойд амьдардаг хар, талд амьдардаг ногоон, ууланд амьдардаг цагаан гурван янзын хүнтэй таарах ба тэд бүгдтэй нөхөрлөн цааш аялан явсаар нэгэн эзгүй байшинтай таардаг. Тэнд идэх хоол унд, үхэр мал тэргүүтэй хүний амьдрахад хэрэгцээт зүйл бүрдсэн байв. Ингээд тэр дөрөв эндээ амьдрахаар шийдэж өдөр бүр нэг нь үлдээд, бусад гурав нь анд явдаг болов. Гэрээ манаж үлдсэн хүн нь тараг бүрж, тос холин, мах чанаад бусад гурвыгаа хүлээх ба энэ хооронд төө хэрийн биетэй, үүрэг үүрсэн эмгэн гарч ирээд, идээ хоолноосоо амсуулахыг гуйдаг. Жаахныг л амсуултал хийсэн тэр бүх хоол унд ор мөргүй алга болно. Үүнд сандарч балмагдсан гэрийн сахиул бусдадаа худал хэлэхээс аргагүй болж, зуугаад морьтой хүн ирээд, би ч тэдэнтэй харвалцаад, эцэст нь тэд дийлж хамаг хоол ундыг дээрэмдсэн тухайгаа ярьдаг. Үнэмшилтэй болгох үүднээс хамаг сумаа хашаа болон газарт хатгаж орхиод, авдар саваа нэгжин байж олсон морин туурайгаар газар сайгүй тамгалж орхисныг үзсэн нөгөө гурав нь үнэмшдэг. Иймэрхүү янзаар хоёр дахь гурав дахь өдрүүдэд эмгэн удаа дараа гарч ирэн, хоол ундыг нь цөлмөх ба гэр сахисан нөхдүүд ч эхний хүний адилаар худал үгийг зохион ярьцгаадаг. Ингээд Тугал ханшаартын гэр манах ээлж болж урьдын ёсоор таргаа бүрж, тосоо холин, махаа чанаж суутал нөгөө эмгэн гарч ирдэг. Эмгэн хоол унднаас нь жаахан амсуурга төдий гуйхад мань хүн юутай ч шууд өгөлгүй, урьдаар усанд явж ирэхийг хүсдэг. Ингэхдээ цаг хожихын тулд шүүрэн шанага болсон хувин өгч явуулах ба өнөөх эмгэн ч дуртай дургүй зөвшөөрч явахад, араас нь шагайж хартал тэнгэр тулам биетэй шулам эмгэн болохыг нь мэддэг. Ингээд ус хутгаад хувин дүүрэхгүй байх завшааныг ашиглаж, эмгэний үүргийг

нэгжиж үзвэл хүний шөрмөсөн дээс, төмөр бахь, төмөр алх байх ба тэд бүгдийг нь модон алх, модон бахь, илжирсэн олсоор сольж тавьдаг. Эмгэн ч уурссан янзтай ирж ус авах хувин ёроол нь цоорхойг хэлж энд байгаа бүх юм минийх тул хүчээ үзээд хэн дийлсэн нь авахаар тохиров. Тэгээд эхний тэмцээн хүлэх сорилтоор эхэлж Тугал ханшаартыг илжирсэн муу олсоор хүлэхэд ядах юмгүй тасалж байна. Харин эмгэнийг хүний шөрмөсөөр хүлсэн тул тайлж ядан бууж өгдөг. Хоёрдох тэмцээн маажилцах сорилт байлаа. Эмгэн модон өрөлбөөр мань эрийг хавчихад ямарваа гэм эс болов. Харин эмгэнийг төмөр бахиар хавчиж мушгин татсанд хэсэг мах өмрөөд унадаг. Эмгэн ч орь дуу тавин бага хүүхэд байтлаа ямар тэнхээтэйг нь гайхна. Гуравдах тэмцээн дэлдэлцэх сорилт болов. Эмгэн модон алхаар Масанг цохиход алхны иш хуга үсэрч ямарваа гэм эс болов. Харин эмгэнийг цохих ээлж болоход нь Тугал ханшаарт төмөр алхаа галд улайсан, толгой түрүүгүй хүчтэй балбасанд цус нөжөө гоожуулан, год харайн зугтаадаг. Энэ үед нөхөд нь ирээд юу болсон талаар даажигнан асуухад Масан тэдний худал хэлснийг зэмлэн донгодоод, эмгэн шулмын араас түүний хамт мөрдөхийг тушаадаг. Тэд цусны мөрөөр хөөсөөр нэгэн хавцлын аманд ирээд, доош үзвэл маш гүн ёроолд нь алт эрдэнэс гялтганан үзэгдэх ба шулам эмгэний үхдэл ч тэнд бас байдаг. Ингээд Масан аргагүйн эрхэнд доош бууж алт эрдэнэсийг дамжуулаад, өөрийг нь татах ээлж болоход гурван нөхөр нь хаяад зугтдаг. Үхэхээс өөр сонголтгүй үлдсэн тэр хоол хайж агуйг бэдэрвээс гурван гүйлсний үр олох ба эрийн сайн Масан мөн болбоос энэ гурван үр унтаад сэрэх хооронд ургах болтугай гээд шулмыг дэр хийн унтваас хэдэн жил гүн нойроор унтаж, сэрээд хартал өнөөх гурван үр нь мод болон ургаад, агуйн амсарт тулсан байхыг үзэв. Тэрээр модоор дамжин агуйгаас гарч, хуучин гэртээ иртэл хэн ч байсангүй ба гагцхүү төмөр нум сум нь хананд өлгөөтэй байхыг үзнэ. Тэндээс цааш явсаар гурван найзын нь гэр байшин харагдаж, дотор нь орвоос тэр гурав өөр өөрсдийн орох оронтой болж, тус бүр эхнэр авцгаасан байв. Нөхрүүд нь хаачсаныг асуувал, анд явсан удахгүй ирэх талаар хэллээ. Масан тэдний замыг тосон очиж уулзвас бүгд айж, амь өршөөхийг гуйн, байдаг бүх хөрөнгө хогшил, эхнэрүүдээ ч түүнд санал болгоно. Масан тэр бүхнийг үл тоож гагцхүү эцгийн ачийг хариулах чухал учиртай тул цааш үргэлжлүүлэн аялна. Тэгээд нэг худгаас ус авах бүсгүйг үзтэл, маш гоо үзэсгэлэн төгссөний дээр, гишгэсэн мөр болгоноос нь цэцэг дэлгэрэхийг хараад, ангайн дагаж алхсаар тэнгэрийн оронд хүрдэг. Тэнгэрийн хаан Хурмаст түүнийг үзээд зөв цагтаа ирсэнд нь талархан, хар болон цагаан бухын тулааныг харуулдаг. Дараа өдөр нь Хурмаст түүнд хар бух болбоос шулмын хувилгаан, харин цагаан бух болбоос тэнгэрийн хувилгаан мөн юм гээд, хар бухын толгойлогчийн тэргүүн магнайд харваж туслахыг гуйдаг. Масан хэлсэн ёсоор нь харваж шархдуулсанд, Хурмаст маш их баярлаж эндээ үлдэхийг гуйх ба Масан эцгийн ач хариулах учиртайг хэлж явах болоход, Хурмаст түүнд явахыг зөвшөөрөх боловч, харин замдаа өөрийн мэдэлгүй зам төөрч, шулмын хааны хотод очихыг түүнд сануулна. Нэгэнт ийм болсон хойно зугтаж зайлах боломжгүй тул шууд хотын хаалганд очоод нүдүүрээр хаалгыг дэлдээд, ямар учиртай болохыг нь асууваас өөрийгөө эмч гэж хэлээрэй. Тэгээд дотогш орж, шархадсан шулмын хааныг эмчлэхийг хүсвэл нь зөвшөөрч, туслах дүр үзүүлэнгээ сумыг тархи руу нь тултал зоож алаад, энэ долоон арвайн үрийг дээш цацагтун хэмээн захиана. Масан замд гарч цааш одтол Хурмастын хэлсэн ёсоор болж, зам эндүүрэн шулмын хотод хүрэв. Тэндээс хаалганы дэргэд байх нүдүүрийг авч дэлдвээс, хааныхын хэн болохыг асуув. Өөрийгөө эмч гэж хэлтэл, тэд дотогш оруулан хааныхаа дэргэд авч ирнэ. Тэгэхэд нь сумыг сугалах дүр үзүүлсэнд, шулмын хаан тайвширч, бие хөнгөрөв хэмээхэд нь долоон арвайгаа цацаж сумыг тултал нь зоогоод, үсрэн зугтвас тэнгэрээс төмөр чагтага унжиж, түүнээс зууран дээш авиртал, шуламсын хатан гал бадарсан бялуугаар нуруун дундуур нь машид хүчтэй дэлссэнд, долоон хэсэг болон бут үсрээд долоон бурхан од болжээ гэхэд түүнийг сонссон Хаан хүү Амгалан явдалт “Ай эцгийнхээ ачийг хариулж чадсангүй дээ” гэхэд нь заяагаа барсан хааны

амнаас үг алдав Сарва дор үл суух хэмээн огторгуйгаар дүүлэн ниссэнээр энэ бүлэг төгсөж байна.

Одоо дээрх үлгэрийн эх бичгийн тухайд хэдэн үг хэлье. Мэдээж монголд тархсан шидэт хүүрийн үлгэр нь Энэтхэг хувилбартай огт төсгүйг хэлэх нь зүйтэй. Харин төвд хэлээр монгол хүн зохиосон эсвэл төвөд хүний зохиолыг монгол хэлэнд орчуулсан эсэх нь эргэлзээтэй. Ямартаа ч Шидэт хүүрийн тав зургаан төвөд хувилбар одоогоор олоод байна. Зарим нь ном хэлбэртэй, зарим судар хэлбэртэй. Хэмжээ дамжаа нимгэн зузаан нь харилцан адилгүй. Монгол хэл дээр 1928 оны хэвлэл, 1962 оны Дамдинсүрэн гуайн хэвлэлийн эх, мөн тод үсгийн нэг тус тус надад байна. Дээрх төвөд монгол судруудын эхтэй орост хэвлэгдсэн зарим орчуулгуудыг харьцуулж үзье.

Эхлээд 1865 орос хэлээр орчуулсан Галсан Гомбоевын хувилбартай танилцъя. Галсан нь буриад гаралтай Галуут нуурын дацанд шавилан сууж байсан лам хүн юм. Казанийн их сургуулийн дорно дахины факультетад профессор Юзиф Ковалевскийн удирдлага дор монгол хэл, төвөд бичиг тэр ч байтугай манж хэл зааж байсан мэдээ байна. Мөн тэрээр түүх шашин соёлын талаар лекц уншиж оюутнуудыг дадлага ажилд удирдан, монголын түүхийн чухал сурвалж болох Алтан товчийг хэвлэгдэхэд чухал хувь нэмэр оруулсан хүн байна.

Гэхдээ энэ орчуулгад анхаарал татсан зарим зүйлийг ажиглалаа. Тухайлбал үлгэр эхлэхэд ингэж гарч байна.

«Когда-то на верьховьѣ одной рѣки жиль бѣднякъ съ женой. У нихъ кромѣ коровы ничего не было. Настало время выгона коровъ въ стадо. Бѣднякъ не находиль быка для своей коровы и въ отчаяніи говорилъ женѣ: «Ну, пропали мы! что будемъ мы дѣлать! Не будетъ у насъ ни молока ни масла! Придется умирать съ голоду и жажды, если единственная кормилица наша пропадетъ!» И онъ имѣль съ нею сообщеніе.

Эртээ урьдын цагт нэг голын эхнээ ядуу эр эхнэрийн хамт аж төрөн суудаг байжээ. Тэдэнд ганц үнээнээс өөр юу ч байсангүй. Үхрээ бэлчээрт гаргах цаг болж, ядуу эр ойр хавиар бухын эрэлд гарсан ч олж чадалгүй цөхрөөд, эхнэртээ ийн хэлэв. За эхнэр минь яадаг хэрэг вэ. Бид ч баларч гүйцэх нь дээ. Үнээ маань хээлгүй хоцорвол бидэнд өрөм сүү хаанаас олдох билээ. Өлсөж цангаж үхэхээс аргагүй болох нь ээ. Тэгээд тэр үнээндээ явсан.

Б.Я.Владимирцовын орчуулгад:

В давнее-давнее время на большой и длинной реке жил одинокий человек; кроме коровы, не было у него никакого другого имущества. Пришло время случки, а быка он не мог нигде разыскать, хотя и искал повсюду. Стал тот человек сильно мучиться в мыслях и подумал так: «Если у моей коровы не будет теленка, то я останусь без айрана и масла и умру от голода и жажды. Так как теперь нет другого исхода, то придется мне самому случиться с коровой!» Подумал он так и случился со своей скотиной.

Тод эхийн орчуулгад:

Эрт урьд нэг их урт голд нэг сухи биетэй хүмүүн ажгуу. Түүнд эд малаас ганцхан үнээнээс өөр юм үгүй. Хэзээ үнээг үржүүлэхийн тулд хамаг зүгт бух эрвээс эс олсонд, маш зовж сэтгэвэй: “Миний энэ үнээ дотор тугал эс болбоос, тос хийгээд айраг үл гарахын тулд, би ундааж өлөж үхмүй [р. 13] хэмээн сэтгээд, өдгөө өөр арга үгүй буй. Би өөрөө явсугай хэмээн сэтгэж, үнээдээ өөрөө тачаав.

1928 онд хэвлэгдсэн Шидэт хүүрийн үлгэрт:

uridu nigen uruu ʧool-un ekin-dür ʧaʧca kümün бүлүге: tegün-dür nigen üniy-e-eče anggida aliba ed ügei ајууу üniyen-i buq-a kögeküi ʧaʧ kürügsen-dür buqan-i aliba жүг-eče eriju ese

Хоёрдугаарт “вмѣнилъ себѣ въ обязанность” буюу өөрийн үүргээ гэж бодсон зүйл нь хийсэн явсан бүх зүйлээ тайлагнах ба үүний дараа хийх зүйл нь “пасть к ногамь его” түүний хөлд сөгдөөд, “облобызать пыль его стопы” өлмийн тоосыг нь “үнсэх” буюу оройдоо тахих явдал байсан гэжээ. Энэ нь жинхэнэ бурхны шашинт хүний толгойд эргэлдэж болох бодол үйлдэл бөгөөд өөрийн ачит хүндээ гаргах сэтгэлийн энэ илэрхийлэл нь уг орчуулгыг ялимгүй дураараа болгосон мэт авч нөгөө талаас нь бодож үзвэл буддын шашны нөлөө туссан нь харагдаж байна.

Б.Я.Владимирцовын орчуулгад:

«Владыка Хормуста очень обрадовался и сказал Беломордому бычку: «Я твой должник! Ты теперь живи здесь!» Но Бычок не согласился, говоря, что должен идти воздать за благодеяние, оказанное ему его отцом. Получил он тогда небесный талисман и уже совсем готов был удалиться,»

Тод эхийн орчуулгад:

«Түүнд хурмаст маш баясаж “Чи их ачит буй. Ашид миний дэргэд суу” хэмээвээс бээр үл болон “Эцгийн ач хариулахаар одох хэрэг бөлгөө” хэмээж тэнгэрийн чандманийг авч яван туурвихад,»

1928 онд хэвлэгдсэн Шидэт хүүрийн үлгэрт:

«Qormusta masi bayasuyad çi yeke açitu bui: nasuda ene oron-dur sayutuyai kemebesü ülü bolun: eçige-yin açi qariyulqui kereg бүлүге odqu bi kemejü tngriş-ün ed-i abuyad odun tuyurbiyşan-dur»

Төвөд шидэт хүүрийн үлгэрт:

བརྒྱ་བྱིན་ཤིན་ཏུ་དགའ་ནས་ཚུད་དྲིན་ཤིན་ཏུ་ཆེ་བ་ཡིན། ཞག་འགར་ངའི་རྩེ་ཚོད་གསུང་ཅུང་མ་ཉན་ཏེ། ང་ནི་ས་ལ་དྲིན་ལན་སྐྱེལ་བར་འགྲོ་དགོས་པ་ཞིག་ཡིད་ཟེར་ནས། ལྷ་རྣམས་ཀྱིས་བྱིན་པའི་འོར་བུ་ཐོགས་ཏེ་འགྲོ་བར་བརྩམས་པ་དང་།

Бас нэг төвөд хувилбарт:

བརྒྱ་བྱིན་ཤིན་ཏུ་དགའ་ནས་ཚུད་དྲིན་ཤིན་ཏུ་ཆེ་བ་ཡིན། ཞག་འགར་ངའི་རྩེ་ཚོད་ཟེར་ཅུང་མ་ཉན་ཏེ། ང་ནི་ས་ལ་དྲིན་ལན་སྐྱེལ་བར་འགྲོ་དགོས་པ་ཞིག་ཡིད་ཟེར་ནས། ལྷ་རྣམས་ཀྱིས་བྱིན་པའི་འོར་བུ་ཐོགས་ཏེ་འགྲོ་བར་བརྩམས་པ་དང་།

Дээрх хэсгийн тухайд Б.Я.Владимирцов хэлэхдээ Масангийн явсан шалтгаан нь “өөрт нь хүргэсэн тусын хариуд эцэгтээ очиж хариу талархах” гэсэн байна.

Тод болон уйгуржин бичгийн хоёр эхэд “эцгийн ач хариулах” гэж шалтгааныг заасан. Гэхдээ энэ хоёр сурвалжид хурмастын дэргэд “ашид” эсвэл “насад” үлдэхийг гуйсан гэж гарсан нь төвөд эхийн дотор гарч буй “хэдэн өдөр” гэдэг санаанаас давсан шинжтэй байна.

Төвөд эхийн тухайд бичлэгийн тухайд онцын ялгаа зөрүү харагдахгүй бөгөөд явсан шалтгааныг мөн л “эцэгтээ ач хариулах учраас” гэсэн байна.

Одоо 1963 оны монгол орчуулгын тухай хэдэн үг хэлье. Энд ойлгомжгүй санагдах зарим үг хэллэгийг авч үзье.

1. модны язгуур: Энэ үг хоёр удаа гарч байна. Язгуур гэдэг үг нь ямар утгатай болохыг та бид мэднэ. Харин модны язгуурт гэсэн нь ойлгомжгүй болсон гэж бодож байна. Тод эхэд модны ёзоорт гэсэн. Миний бодлоор модны ёроолд гэж байвал болмоор санагдах.

2. чамуурхаж өгүүлсэн: Чамуурхах гэж юу гэсэн үг болохыг мэдэхгүй. Чамирхах гайхуулах гэсэн үг болов уу. Хэрэв тийм гэж үзвэл тайлбар оруулах нь зүйтэй. sdong po'i rtsa bar kha po ngag dag smras pa/

3. сухи: ганц бие гэсэн утгатай үг бололтой. pho rangs pa/

4. яв юмгүй: өөр хогшил хөрөнгөгүй гэсэн утга байна. de la nor du byas pa ba gcig min pa sang med do/

5. бяруу тэргүүт: Үлгэрийн нэр бол тугал ханшаарт гэж байгаа. Харин бяруу тэргүүт гэсэн нь төөрөгдүүлсэн шинжтэй байна. Аль нэгийг нь сонгоод нэрлэх нь зүйтэй.

6. нөхцөж явтал: Хэд хэд гарч байна. Нөхөрлөж явтал гэвэл одоо үед илүү зохих.

7. өлөн: Өвсийг хэлсэн бололтой. Хуучирсан үг тул тайлбарлах.

8. сал овоо: Төвөд эхэд бол шил овоо гэж байна.

9. салаас төрсөн: Шилээс үүссэн гэж төвөд эхэд байна.

10. нөхцөлдье: нөхөрлөө гэсэн утгатай.

11. дотоод хэрэг ярагтан: Ярагтан гэж үгийг хэрэгцээтэй эд хэрэгсэл гэж тайлбарлаж болох юм.

12. имаа: Одоо гэсэн үг.

13. байшинг эргэж бүрүүн: Байшинг тойрч бүсэлсэн гэж төвөд эхэд гарч байна.

14. жүнчих: Жанчих бололтой.

15. ниших, нишгэх: цохихын нэр бололтой.

16. савын ёроолоор садаргарах: асгарах гоожих гэсэн үг бололтой.

17. данхайн төдий: данхын төдий бололтой.

18. бие тэргүүн үгээгүйеэ нишгэсэнд: толгой түрүүгүй цохисонд

19. Эс арилжиж: Эр хүн шиг байсангүй гэж төвөд эхэд гарч байна.

20. номхотгозном: Аль хэдийн номхруулчихсан гэж төвөд эхэд гарч байгаа ба дээрх үгийг харвал хийхээр завдан буй мэт болсон тул санааг бүрэн илэрхийлэхгүй байна.

21. бээрийн төдий: Бээр гэдэг бол нэлээд их хэмжээтэй уртын хэмжүүр тул уншигчийн төсөөлөлд буухгүй гэж үзэж байна.

22. хожуул болтугай: Хожуул бус харин ч гүйцэд сайн урт мод ургаад агуйгаас гарах хүслээ шивнэж байдаг.

23. хөнөөмүй: Хар цагаан бухнууд бие биеэ хөөж байна гэж гардаг болохоос алж хөнөөсөн тухай аль ч хувилбарт байхгүй байна.

24. Зуур мөрт унтраад: Замдаа нойр ихэд хүрч зүүрмэглэх тухай төвөд үлгэрт гардаг. Унтраад гэж буруу хуулагдсан болов уу.

25. эндрэх: Эндүүрэх гэж байсан болов уу.

26. сумны тэргүүнийг дунд түлхэж алагтун: Сумыг тэргүүний /тархины/ голд тултал зоож алагтун гэж төвөд эхэд байна. Монгол нь тун ойлгомжгүй болсон байна.

27. хотчилохуй: Оточлох гэж уншихыг ташаарсан болов уу. Оточ хийдэг гэсэн үгний үйл үгийн хэлбэр бололтой.

Дээрх үг хэллэгийг 1963 оны Шидэт хүүрийн нэгдүгээр дэвтэрт тайлбарлаагүй. 2017 оны дахин хэвлэлд ч тайлбарлаагүй тул уншигч олонд төдий л ойлгомжгүй санагдсан байх магадгүй хэмээн санаад энэ мэт тайлбар оруулах нь зүйд нийцэх болов уу гэж бодном.

4. Дүгнэлт

Монголчуудын дунд ихэд дэлгэрсэн шидэт хүүрийн үлгэр нь бидний хувьд үнэ цэнтэй бичгийн дурсгал болно. Бид өмнөх үеийн эрдэмтэн судлаачдын үйл хэргийг үргэлжлүүлэн, нарийвчлан судлах шаардлагатай. Энд дээрх үлгэрийн ганц бүлэгт л бага шиг хэмжээний ажиглалт хийсэн бөгөөд үүнийг цааш гүнзгийрүүлэн өргөжүүлж бүлэг тус бүрээр нь хийвэл зохилтой. Ерөөс эх бичгийн судалгааг харьцуулж хийх, өөр хэл дээр гарсан орчуулгуудтай тулгаж нягтлах нь нэг талдаа сурвалжийн үнэ цэнийг тодруулах ач холбогдолтой ба нөгөө талдаа гадны эрдэмтдийн судалгаа шинжилгээ үнэхээр сайн, нягт нямбай болдог эсэхэд хариулт өгөх сайхан завшаан болно гэж бодно. Дээр дурдсанчлан дахин хэвлэх тохиолдолд хянамгай няхуур хандах ёстойг ч энэ дашрамд хэлэхэд илүүдэхгүй. Миний санахад тод үсгээр хэвлэсэн эх, 1928 оны эх,

Галсан Гомбоев болон Владимирцов нарын орчуулгыг уншихад маш ойлгомжтой сайхан санагдсан гэдгийг хэлэх нь зүйтэй.

Ном зүй:

Галсан Гомбоев (1865) *Шидди-кур*. Санкт-Петербург

Владимирцов Б.Я. (1958) *Волшебный мертвец* Москва

Дамдинсүрэн, Ц. (1962-63) *Төвөд монгол шидэт хүүрийн үлгэр* 1-2 боть. Улаанбаатар.

Ts.Damdinsuren *Tövöd mongol shidet khüüriin ülger* Ulaanbaatar 1962-63

Ro dngos grub can gyi gтам rgyud. Гар бичмэл судар.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>